

## ГАРЧИГ

1. ТУХАЙН ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	4
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	6
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	10
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	12
5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	13
6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	18
7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН .....	21
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	21
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН .....	22
БҮСИЙН ОРШИНСУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	22
9. ДҮГНЭЛТ .....	23



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000507294 дугаартай 7.5 га газрын булангийн цэгүүд .	4
Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	6
Хүснэгт 3. Төслийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт .....	10
Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	12
Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	13
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....	18
Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	21
Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт .....	22



## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг.....	5
Зураг 2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээндхийсэн ажил	8
Зураг 3. Ариун цэврийн өрөөний бочкинд усны зарцуулалтыг их болон бага хувилбараарсонгох хос даралтат товчлууруу суурилуулсан.....	8
Зураг 4. Лед гэрэл.....	9
Зураг 5. Төслийн талбайн ногоон байгууламж.....	11
Зураг 6. Хог хаягдлын гэрээ №1.....	14
Зураг 7. Хог хаягдлын гэрээ №2.....	15
Зураг 8. Хог хаягдлын гэрээ №3.....	16
Зураг 9. Хог хаягдлын гэрээ №4.....	17
Зураг 10. Усны лабораторийн шинжилгээний үр дүн.....	19
Зураг 11. Хөрсний лабораторийн шинжилгээний үр дүн.....	20

## 1. ТУХАЙН ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** “Жирмийн цагаан нуур” аялал, жуулчлалын баазын төсөл

**Төслийн зорилго:** Уул толгодоор хүрээлэгдсэн, цэцэг навч алагласан, цэнгэг агаартай байгалийн үзэсгэлэнт газар дотоодын жуулчид төдийгүй гадаадын жуулчдыг түлхүү хүлээн авч XIII зуун, Монголын эзэнт гүрний түүх соёл, ёс заншил, онгон байгальтай танилцуулах, алжаалыг нь тайлахуйц дээд зэрэглэлийн үйлчилгээ үзүүлэх зорилготой.

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:

- “Хос-Оюу” ХХК
  - Хувийн хэргийн дугаар:9011009028
  - Регистрийн дугаар: 2652323

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, 4-р хороолол, 29 -53 тоот
- Утас: 976-99145233

**Төслийн байршил:**

Төв аймгийн Аргалант сумын нутагт байрладаг ба Улаанбаатараас 50 км зайд оршдог.

- Талбайн хэмжээ: 7.5 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-48-9


**Газарзүйн солбицол**

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000507294 дугаартай 7.5 га газрын булангийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	106	7	55.0	47	56	28.6
2	106	7	55.1	47	56	35.5
3	106	8	12.1	47	56	34.9
4	106	8	11.7	47	56	28.0



Төв аймгийн Аргалант сумын нутагт орших “Хос оюу” ХХК-ийн “Жирмийн цагааннуур” аялал, жуулчлалын баазын төслийн 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг





## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	ХЭРЭГЖИЛТ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1	2	3	4	5	
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ					
1	Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбайгаас гарсан хог хаягдлыг тогтсон нэг цэгт хаяж ил шатаах үйл ажиллагаа явуулж байгаагүй.	Үйл ажиллагааны зардал	
2	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хортхий ялгарах	Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтрааж байх	Төсөлд хэрэглэгдэх авто тээврийн хэрэгсэл болон амрах гэж ирж буй хүмүүст шаардлагагүй тохиолдолд машинаа унтрааж байхыг анхааруулж ажиллаж байсан.		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ					
3	Усан орчин бохирдох, Усны нөөцхөмсдох	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Барилга байгууламж болон бусад хур хуримтлуулах боломжтой газруудад борооны ус хуримтлуулах сав, тоног төхөөрөмжийг байршуулж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
4		Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/	Аялал жуулчлалын бааз болон ажилчдын ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
5		Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	“Жирмийн цагаан нуур” аялал жуулчлалын бааз нь ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
5	Усны чанар	Цэгийн орчны газрыг тэгшилж, хур борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж гадаргын урсац зайлуулах суваг татах	Төслийн талбайд хур борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж гадаргын урсац зайлуулах суваг татаж өгч ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
7		Бохир ус зөөвөрлөх машин чөлөөтэй орж гарах талбайтай байна.	Төслийн талбайд бохир ус зөөвөрлөх машин орж гарах талбайг засаж орох гарах хөдөлгөөнд саадгүй байхаар зохицуулж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
8		Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.	Бохир ус зайлуулах цооног дүүрэх үед тухай бүр суллаж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисоор тогтмол халдваргүйжүүлж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ					
9	Хөрсний бохирдол	Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Төслийн хог хаягдлыг орон нутагтай хийсэн гэрээний дагуу зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
10		Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах	Амрагч болон ажилчдын авто машинаас тос асгарах тохиолдолд тухай бүр цэвэрлэж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хөрс бохирдохоос сэргийлж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	

Төв аймгийн Аргалант сумын нутагт орших “Хос оюу” ХХК-ийн “Жирмийн цагааннуур” аялал, жуулчлалын баазын төслийн 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	Хэрэгжүүлсэн	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
11		Тээврийн хэрэгслийн /авто/ зогсоолыг байр, сууц, байгууламжаас 200 м-ээс багагүй зайд байрлуулах ба тээврийн хэрэгслийн зогсоол нь “MNS 5342:2007, Автомашинны зогсоол, ангилал, ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангасан байна.	Тээврийн хэрэгслийн /авто/ зогсоолыг байр, сууц, байгууламжаас 200 м-ээс багагүй зайд байрлуулж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны зардал	
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ					
12	Ургамал	Аялал, жуулчлалын баазын хашаан доторх сулчөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Төслийн талбайд ногоон байгууламжийг зохистой хэмжээнд тохижуулж сул чөлөөтэй талбайг тарималжуулж ажиллаж байсан.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд зардал тусгагдсан	
Эрчим хүч					
13	Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмжийг сонгож хэрэглэх	Амралтын байр болон ажилчдын байранд эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг суурилуулж ажиллаж байсан.	Үйл ажиллагааны зардал	
<b>Нийт</b>				-	



Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний хүрээнд тэмдэг тэмдэглэгээ байршуулж, төслийн талбайн явган хүний зам талбайг хатуу хучилттай болгон зассан.



Зураг 2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хийсэн ажил

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний хүрээнд баазын ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулсан.



Зураг 3. Ариун цэврийн өрөөний бочкинд усны зарцуулалтыг их болон бага хувилбараар сонгох хос даралтат товчлуур суурилуулсан





Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож баазын гадна, доторгэрэлтүүлэгт лед гэрэл хэрэглэж байна.



Зураг 4. Лед гэрэл



### 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Төслийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

№	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	ХЭРЭГЖИЛТ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4
1	Ногоон байгууламж бий болгох Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	Ногоон байгууламжийг бий болгох ажлын хүрээнд 100 ш чацаргана, 100 ш үхрийн нүд, бусад жимсний модыг тарьсан. Мөн төсөл хэрэгжүүлэгч нь амрагчдыг эрүүл хоол хүнсээр хангах зорилгоор төслийн талбайд хүнсний ногоо тарьсан.	500,000.0	





Зураг 5. Төслийн талбайн ногоон байгууламж



#### 4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөхтүүх, соёлын өв	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөнийтүүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил	ХЭРЭГЖИЛТ	Нийт зардал
	1	2	3	4
1	Археологийн болон Палеонтологийн дурсгал	Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төслийн талбайд соёлын биет өв илрээгүй болно.	-
<b>Нийт дүн</b>				-



## 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил	ХЭРЭГЖИЛТ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
1	Ахуйн хог хаягдал	<p>Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах</p>	<p>Төслийн талбайд үүсэх хог хаягдлыг ангилал тус бүрээр ангилан ялгаж ажиллаж байсан.</p> <p>Хог хаягдлыг хогийн цэгт цуглуулан, хог хаягдал тээвэрлэх байгууллагатай хийсэн гэрээний дагуу тогтмол зайлуулж ажиллаж байсан.</p>	-	-
<b>Нийт дүн</b>				-	-







➤ Хог тээврийн гэрээ



Зураг 6. Хог хаягдлын гэрээ №1



Зураг 7. Хог хаягдлын гэрээ №2



Зураг 8. Хог хаягдлын гэрээ №3





## 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэг байршил	ХЭРЭГЖИЛТ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
<b>Хөрсөн бүрхэвч</b>					
1	Хөрсний шинжилгээ	- Төслийн талбайд 1 цэгт	Хөрсний хүнд металл 200-300 гр хэмжээтэй авч “Нарт Шуун Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	25,000.0	25,000
<b>Усны чанар</b>					
3	Ерөнхий хими	- Унд, ахуйн хэрэглээний уснаас-1 цэг	Унд, ахуйн хэрэглээний уснаас нэг усны сорьц авч шинжлэх ухааны академи газарзүй-геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав).	46,000.0	46,000.0
<b>Нийт дүн</b>					<b>71,000.0</b>





➤ Усны шинжилгээний лабораторийн үр дүн



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН  
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2023 оны 10 сарын 22 өдөр  
Шинжилгээ хийсэн: 2023 оны 10 сарын 27 өдөр  
Сорьц авсан газрын нэр: Төв аймаг, Аргалант сум, Хөшөөт баг  
"Жирмийн Цагаан Нуур", гүний худаг  
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Баялаг Баян Ундарга" ХХК

Солбицол: X= Гүн:  
Y= Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

Анион	1дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1дм <sup>3</sup> -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl <sup>-</sup>	39.1	1.10	12.2	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	71.4	3.10	34.4
SO <sub>4</sub> <sup>2-</sup>	65.0	1.35	15.0	Ca <sup>2+</sup>	60.1	3.00	33.3
NO <sub>2</sub> <sup>-</sup>	0.0	0.00	0.0	Mg <sup>2+</sup>	35.3	2.90	32.2
NO <sub>3</sub> <sup>-</sup>	10.0	0.16	1.8	NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.2	0.01	0.1
CO <sub>3</sub> <sup>2-</sup>	0.0	0.00	0.0	Fe <sup>2+</sup>	0.0	0.00	0.0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	390.4	6.40	71.0	Fe <sup>3+</sup>	0.0	0.00	0.0
Дүн	504.5	9.02	100.0	Дүн	167.0	9.02	100.0

HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын

нийлбэр: 476.2 мг/дм<sup>3</sup>

Ерөнхий хатуулаг 5.90 мг-экв/дм<sup>3</sup>

pH: 8.03

Исэлдэх чанар:

1.28 мг/дм<sup>3</sup>

Физик шинж чанар

Тунгалаг: >30 см

Үнэр: үгүй

Өнгө: үгүй

Амт: \*\*\*

Анион катионуудын

нийлбэр: 671.4 мг/дм<sup>3</sup>

EC: 780 µS/cm

TDS: 446 ppm

Тунадас: үгүй

Булингаршил: 0.25 NTU

HCO<sub>3</sub><sup>-</sup> 71 SO<sub>4</sub><sup>2-</sup> 15 Cl 12

Усны найрлагын томъёо: M<sub>0.67</sub>

Na<sup>+</sup>+K<sup>+</sup> 34 Ca<sup>2+</sup> 33 Mg<sup>2+</sup> 32

Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, хөлийг бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатууатар ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс магнийн ион нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018" стандартад заасан хэмжээнээс их байгаа учир зөөлрүүлж хэрэглэх хэрэгтэй.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Хийсэн: Химич, ЭШДА: Магистр (M.Sc)  / Д.Эрдэнэцэг/

Шинжилгээг

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч:  Д.Гэрэлт-Од/

Зураг 10. Усны лабораторийн шинжилгээний үр дүн

➤ Хөрсний шинжилгээний лабораторийн үр дүн



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК  
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836  
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/10-16/1

Захиалагч: “Баялаг баян ундарга” ХХК  
Дээж авсан цэг: “Хос Оюу” ХХК, Төв аймаг, Аргалант сум  
Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 12 өдөр  
Шинжилгээ гарсан огноо: 10 сарын 16  
Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. II Р ХӨРСӨНД

№	Дээжний лугаар	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 3297:2019			Анаэробын (Cl.perfringens) MNS 3297:2019	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
1	Дээж 1	0.7*10 <sup>5</sup>	1	1	0.1<	1	

\* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ  
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Т.СОЛОНГО Ph.D, Дэд профессор



Нарт ШУУН Консалтинг ХХК

2023 ОНЫ 10 САРЫН 16 1

Зураг 11. Хөрсний лабораторийн шинжилгээний үр дүн



### 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөсөн ажлууд	ХЭРЭГЖИЛТ
1	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай харилцан тохиролцож ажилласан.
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож ажилласан.
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОАЖЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	БОМТ болон биелэлтийн тайланг хариуцах мэргэжилтэн томилж, хуульд заасан хугацаанд өгч ажиллаж байсан.
<b>Нийт дүн</b>		-



### 8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИНСУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө	ХЭРЭГЖИЛТ
1	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлж тайлагнах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлж тайлагнаж байсан.
<b>Нийт дүн</b>		-



## **9. ДҮГНЭЛТ**

Төв аймгийн Аргалант сумын нутагт байрлах “Хос оюу” ХХК-ийн “Жирмийн цагааннуур” аялал, жуулчлалын баазын төслийн 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 – ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- “Хос оюу” ХХК нь 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт 572,000 төгрөг зарцуулсан байна;





